



## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар А/216

Улаанбаатар хот

### ЖАГСААЛТ, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, журмыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл болон санхүүгийн програмд зохих өөрчлөлт хийж хоорондын уялдааг нь сайжруулах арга хэмжээ авахыг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, зохион байгуулалтад мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (Ж.Нарангэрэл)-т, төлбөртэй тусламж, үйлчилгээний журмын хэрэгжилт, салбарын санхүүжилтийн бодлоготой уялдаж буй талаар судалгаа, дүн шинжилгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Буянтогтох)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Жагсаалт, журам батлах тухай" Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/470, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/117 тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

САЙДС.ЭНХБОЛД